

*“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар хавсралт*

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

2020.06.15

Улаанбаатар хот

Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Зүйл, заалтын дугаар	Шийдвэрийн агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ	Тасарсан болон удааширсан шалтгаан
1	2	3	4	5	6
<b>1.е.Засгийн газрын тогтоол</b>					
2018.08.22 № 258 Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай	1.1.	Харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх	Монгол улсын Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоолоор улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108, А/166, А/168 дугаар захирамжийг үндэслэн газрын даргын 2020 оны А/14 дүгээр “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан ажлын тусгай горимд шилжүүлэх, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай”, А/15 дугаар “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хариуцлагатай эргүүл, жижүүр томилох тухай” тушаал баталж, нийт ажилтан, албан хаагчид 6 сарын турш ажлын тусгай горимд шилжин, сахилга хариуцлагыг сахин ажиллаж байна. Мөн төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ	89%	НЗД-ын 2017 оны А/335-р захирамжид заасны дагуу Авлигын эсрэг төлөвлөгөөн ий биелэлтийг 2020.07.10-ны өдрийн дотор, Төрийн албан хаагчийн ёс зүйн

			<p>зөрчсөн ажилтан, албан хаагчид хариуцлага тооцсон талаарх мэдээг дараах байдлаар эрх бүхий байгууллагад хүргүүлж байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр НЗДТГ-ын ТЗУХ-т;</li> <li>• Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг улирал бүр НЗДТГ-ын ТЗУХ-т.</li> </ul>		зөрчлийн мэдээг 2020.06.30-ны өдрийн дотор илгээнэ.
	1.2.	<p>Иргэдийг ялгаварлан гадуурхахгүй ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг өгөх, цаашид өргөдөл, гомдлыг хугацаанд нь бодитой шийдвэрлэж хэвшүүлэх</p>	<p>2020 оны эхний хагас жилд нийт 79 өргөдөл ирснээс 77 өргөдлийг шийдвэрлэж, хариуг өргөдөл гаргагчид танилцуулсан ба 2 өргөдөл судлагдах шатанд байна. Тайлант хугацаанд өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн зөрчилгүй, өдөрт нь багтаан хүлээн аваагүй 1 зөрчил, явцын тэмдэглэл хөтлөөгүй 1 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчийн үзүүлэлт нэмэгдээгүй байна.</p> <p>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног 11 цаг 31 минут байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 хоногоор өссөн, өмнөх улиралтай харьцуулахад 2 хоногоор буурсан байна. Энэ нь ажилтны санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцлаж буй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т заасан хугацааг баримтлах болсонтой холбоотой юм.</p> <p>Хандалтын хувьд 2019 оны эхний хагас жилд 91, сүүлийн хагас жилд 110 өргөдөл бүртгэгдсэн бол 2020 оны эхний хагас жилд 79 өргөдөл бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 31 өргөдлөөр буюу 28,2 хувиар буурчээ. Дээрх үр дүн нь ажилтан, албан хаагчаас ирүүлсэн санал хүсэлтийг тухай бүр хүлээн авч, түргэн шуурхай, үндэслэлтэй шийдвэрлэж буйтай холбоотой юм.</p>	100%	

	1.3.	Төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах	Ажлын байрны чиг үүргийн давхцал үүсгэлгүйгээр ажлын ачааллыг зөв цэгцтэй хуваарилах, хөдөлмөрийн сахилгыг чанд сахиулж, ажлын бүтээмжийн нэмэгдүүлэх зорилгоор тайлант хугацаанд нийт 14 ажилтан, албан хаагчийг байгууллага дотор шилжүүлэн ажиллуулж, ажлын цаг ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авч ажилласан. Мөн НЗД-ын 2020 оны А/108 дугаар захирамжийн дагуу Хан-Уул дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 2020.02.20-ны өдрөөс 2020.05.31-ний өдрийг дуустал хоёр ээлжээр эргүүлийн үүрэг гүйцэтгэж, давхардсан тоогоор 10 мянга гаруй иргэдэд коронавируст /Ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын тархалтыг нэмэгдүүлэхгүй байх шаардлага тавьж, 5633 аж ахуйн нэгж, иргэдэд шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж тараасан. Энэхүү ажлыг зохион байгуулахдаа ажилтан, албан хаагчдын үндсэн ажил үүргийг алдагдуулахгүйгээр эргүүлийн үүрэг гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлж, ажлын ачаалал, чиг үүргийг зөв хуваарилан, орлон ажиллах зарчмыг хангаж ажилласан болно.	100%	
	1.4.	Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар	Байгууллагын мэргэжлийн албан хаагчийн сул орон тоог нөхөхдөө Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан чадахуйн /мерит/ болон шатлан дэвшүүлэх зарчмыг удирдлага болгон ажиллаж байна. Тайлант хугацаанд тооцооны нягтлан бодогч Х.Бямбанаранг агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогчоор, зоогийн газрын зөөгч Д.Оюунтуяаг байр хариуцсан менежерээр, тоног төхөөрөмж хариуцсан	100%	

		төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх	<p>техникч Б.Эрдэнэтөгсийг зоогийн газрын менежерээр, зоогийн газрын касс Г.Мөнхцэцэгийг үндсэн хөрөнгө, бараа материалын нярваар, байрны жижүүр Н.Энхбатыг тоног төхрөөмж хариуцсан техникчээр, зоогийн газрын сав угаагч О.Давааг тогоочоор, тус тус дэвшүүлэн томилсон.</p> <p>Энэхүү ажлын үр дүнд ажилтан, албан хаагчид идэвх санаачилгатай, тогтвор суурьшилтай ажиллах сэдэл бүрдэж буй нь 2019 оны эхний хагас жилд өөрийн санаачилгаар 14 ажилтан, албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн бол 2019 оны эхний хагас жилд байдлаар энэ үзүүлэлт 14 болж, өмнөх оны мөн үеэс 57,6 хувиар буурсан байна.</p>		
	1.6.	Төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх	Жирэмсний болон амаржсаны амралттай байгаа 31 ажилтан, албан хаагчийн ажлын байрны сул тоонд мөн тооны ажилтан, албан хаагчийг хугацаатай хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж буй бөгөөд гэрээт ажилтан ажиллуулдаггүй болно.	100%	
	1.7.	Төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд	Тайлант хугацаанд 4 ажилтны ажлын байранд архидан согтуурсан гэх үйлдэлд сонсох ажиллагаа явуулж, ёс зүйн зөвлөлөөс гаргасан саналыг үндэслэн	100%	

		согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох	1 ажилтанд ажлаас халах, 2 ажилтанд сануулах сахилгын шийтгэл ногдуулж, 1 ажилтанд ёс зүйн зөвлөлийн хурлын тэмдэглэлээр сануулах арга хэмжээ авлаа.		
	1.8.	Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	Ажилтан, албан хаагчдын гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх чиглэлээр үе шаттай ажлууд хэрэгжүүлсний үр дүнд 2018 онд 17, 2019 онд 11, 2020 оны эхний хагас жилийн байдлаар 4 ажилтан, албан хаагч ёс зүйн зөрчил гаргаж, зөрчлийн тоо тогтмол буурч байна.	100%	
	1.10.	Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах	Тайлант хугацаанд ёс зүйн зөвлөл 3 удаа хуралдаж ажлын байранд архидав согтуурсан ёс зүйн зөрчил гаргасан 4 ажилтанд дүрэм журмын дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан ба 2-р улиралд ёс зүйн зөрчил гаргасан ажилтан, албан хаагч байхгүй болно. Байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд эерэг таатай уур амьсгал хэвээр хадгалагдаж буй нь харилцаа хандлага, зан байдлын шинжтэй холбоотой гомдол санал ирээгүй байдлаар илэрч буй болно.	100%	
	3.	Төрийн албаны соёл, дэг журмыг	Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн үйл	100%	

	<p>сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.</p>	<p>ажиллагаанд дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөө, календарьчилсан хуваарийн дагуу 2020 оны эхний хагас жилд дараах чиглэлээр хяналт шинжилгээний ажил зохион байгууллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ;</li> <li>- Зоогийн газар, цайны газруудын үйл ажиллагаа;</li> <li>- НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбарууд, Баянхошуу дэд төвийн цэвэрлэгээ үйлчилгээ болон ариутгал, халдваргүйжүүлэлт;</li> <li>- Байр ашиглалтын албаны үйл ажиллагаа;</li> <li>- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, эхний хагас жилийн ажлын дэлгэрэнгүй тайлан, дүрмээр хүлээсэн чиг үүргийн биелэлт болон тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц.</li> </ul> <p>Хяналт-шинжилгээний дүнг газрын удирдлагуудад танилцуулан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, ажил сайжруулах хугацаатай үүрэг даалгаврыг холбогдох албан хаагчдад өгч ажилласан.</p>		
Хэсгийн дундаж: 98,9 хувь				

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:  
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН  
ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

Э.ХОРОЛДУЛАМ